

АМИА ЕГҮҮТГЭХ ХЭРЭГ, УЧРАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛД

SUICIDE, CIRCUMSTANCES OF COMMITMENT AND SOME PROBLEMS OF PREVENTION



Б.САРУУЛ Цагдаагийн Ерөнхий газрын Судалгааны төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

SARUUL B. Senior specialist of the Research Center, General Police Agency, police major

Товч агуулга: Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол улсын Үндсэн хуульд тунхаглан тодорхойлогдсон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ялангуяа иргэний амьд явах, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах төрийн үүрэг мөн. Монгол Улсын Үндсэн хуульд иргэн нь амьд явах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ” хэмээн хүний халдашгүй дархан эрхийг тунхагласан⁵. Харин гэмт явдлын байдал, хөдөлгөөн, бүтэц, шинж чанарт өөрчлөлт гарч гэмт хэрэг үйлдэх арга нь улам нарийн болж олон нийтийн анхаарал татсан хүний амь нас хохирсон тохиолдлууд бүртгэгдсээр байна.

Abstract: Universal Human right declaration and the Constitution of Mongolia declare that the state has the duty to protect human rights and freedom of their citizens, especially the right to life as well as to live in a safe environment. The Constitution guarantees the citizens of Mongolia have the fundamental right to life. Unfortunately, characteristics, movement and structure of crimes have been changed a lot and it has still been registered sensational murder offences committed by more rational methods

Амиа егүүтгэх нийгмийн сөрөг үзэгдлийн өнөөгийн байдал

Иргэд золгүй байдлаар нас барсан болон амиа егүүтгэсэн хэрэг, учралыг сүүлийн 2012, 2013, 2014 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нэгтгэн үзвэл:

№	Нас барсан хэрэг учрал	2012 онд			2013 онд			2014 он		
		Жил	Дундаж		Жил	Дундаж		эхний 10 сард	Дундаж	
			сар	Хоног		сард	Хоног		сард	Хоног
1	Золгүй байдлаар	2584	215	7	2370	197	6	1911	191	6
2	Амиа хорлож	515	43	1	410	34	1	420	42	1
3	Нийт	3099	258	8	2780	231	7	2331	233	7
Золгүй байдлаар 6865 , амиа егүүтгэсэн 1345 , нийт 8210 золгүй болон амиа егүүтгэх тохиолдол бүртгэгдсэн.										

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1 “... Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно”

Нийт 8210 хэрэг бүртгэгдсэн нь жилд дунджаар 2736 хүн, сард 228, өдөрт 7 хүн золгүй байдлаар болон амиа егүүтгэж нас барсан гэсэн статистик байна.

2014 оны эхний 10 сарын байдлаар нийт 2331 хэрэг, учрал⁶ бүртгэгдсэн нь сард дунджаар 233, өдөрт 8 хүн нас барсан байх бөгөөд үүнээс золгүй байдлаар 1911, амиа егүүтгэсэн 420 хэрэг шалгагдсан байна.


Статистикийн үзүүлэлтийг тодорхойлох программчлал, мэдээллийг шивж оруулж байгаа алба хаагчийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, ажлын хариуцлагаас шалтгаалсан үнэн бодит мэдээлэл гарах явдал харьцангуй ойлголт болно.

Түүнчлэн монголчуудын амиа егүүтгэж байгаа шалтгааны цогц судалгаа үгүйлэгдэж байгаа нь эрүүл мэндийн байгууллага болон шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны сөрөг хандлагыг илэрхийлж байна.

Энэ нь тухайн байгууллагууд мэдээллийг нууцалдагтай холбоотой юм.



Амиа хорлож нас барсан үйлдлийг цаг хугацааны хувьд авч үзвэл 2, 3, 5 дугаар сард хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна. Улирлын байдлаар нэгтгэн үзвэл хавар, зуны улиралд харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.⁷




Нийт амиа хорлогдсдын 79.6 хувь нь эрэгтэй, 20.4 хувь нь эмэгтэй хүн байна.

2010 оны байдлаар 10000 хүн амд ноогдох амиа егүүтгэх тохиолдол эрэгтэйчүүдэд 2.72, эмэгтэйчүүдэд

0.49 хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс амиа егүүтгэх хэрэг учрал 5.5 дахин их байсан байна.⁸


Амиа егүүтгэгчдийг насны байдлаар нь авч үзвэл 36-аас дээш насныхан дийлэнх хувийг, хүүхэд багагүй хувийг эзэлж байна.

Амиа егүүтгэгчдийн насны байдал /2012-2014 оны 10 сарын статистик/




Эндээс үзэхэд гагцхүү хүүхдүүд амиа хорлох оролдлого хийдэггүй, мөн 35-аас дээш наснаас хүн ч ийм болчимгүй алхам хийдэг байна.

Амиа егүүтгэсэн арга /2012-2014 оны 10 сарын статистик/



Амиа егүүтгэгч өөрийгөө буудах, боомилох, хутгалах, хордуулах байдлаар ихэвчлэн гэр, орон сууцанд үйлдэгдэж байна.

Амиа егүүтгэх тохиолдол гарсан газар орон /2012-2014 оны 10 сарын статистик/



Амиа егүүтгэгчдийн боловсролын төвшин /2014 оны 10 сарын статистик/




⁶ Цагдаагийн байгууллага сэжигтэй буюу гадны нөлөөтэй нас барсан байж болзошгүй тохиолдлуудад хойшлуулшгүй ажиллагаа явуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг.

⁷ ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС, СЭМТ "2003-2008 онуудад Монгол улсад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлын тархалт" судалгааны ажлын тайлан, УБ,

⁸ Дээрхи судалгааны тайлан

Амиа егүүтгэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүд

- Амиа егүүтгэсэн тохиолдол нийслэл, зарим аймагт харьцангуй өндөр байгаа нь хотжих үйл явц тэр дундаа хүн амын нягтаршил, ажилгүйдлийн төвшин, газар зүйн байршил, амралт, зугаалга, аяллын чиглэл дайран өнгөрдөг газар зүйн онцлог, тэдгээрийг дамжин өнгөрдөг төмөр зам, авто замын дэд бүтцийн хөгжил, архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тархалт зэрэг олон хүчин зүйлээс улбаатай. Хүн амын нийслэл рүү шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд маш их идэвхжсэн нь орон нутгаас нийслэлд ирсэн иргэдэд ажил олдохгүйгээс амьжиргааны эх үүсвэргүй болох, бичиг баримтын зөрчилтэйн улмаас нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байдалд орох, хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, амьдралын өртөг өндрөөс ядууралд орох, гэр бүлийн хүмүүсээ тэжээх чадваргүй болох байдалд орж байгаа нь архи уух, гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдох, амиа егүүтгэх хүртэл сөрөг үр дагаварыг дагуулж байна.
- Нийтийг хамарсан арга хэмжээ, тэмдэглэлт ой, өдрийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж тэмдэглэх нь архинд хордох, осгож хөлдөх, түлэгдэх, усанд живэх, болгоомжгүйгээр өндрөөс унах зэргээр золгүй байдлаар амь насаа алдаж байна.⁹ Түүнчлэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт буюу бидний хэлж занснаар хар тамхины аюул хэдийнээ үндэсний аюулгүй байдалд заналхийлж улмаар борооны дараах мөөг шиг эмийн бөөний худалдаа ялангуяа мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хяналтгүйгээр зарж борлуулж байгаа нь амиа егүүтгэх нөхцлийг бүрдүүлж байна.
- Амиа хорлогч өөрийгөө егүүтгэх нь тухайн хүний сэтгэл зүйн онцлог ялангуяа гадны нөлөөллийг хүлээн авах чадвар буюу сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй шууд холбоотой байдаг. Тухайлбал, “2003-2008 онуудад Монгол Улсад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлын тархалт” судалгааны ажлын тайланд дурьдснаар сэтгэц эмгэг оношоор амиа егүүтгэсэн тохиолдлыг харьцуулахад дараах нөхцөл байдал дүгнэгдсэн байна.



⁹ Европт хийсэн нэгэн судалгаагаар нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэрэглээг 10,0 хувиар багасгахад согтууруулах ундаанаас хамаарах эрэгтэйчүүдийн үхлийг 20,0 хувиар, золгүй осол, амиа хорлох, бусдын амь нас хохироох явдлыг 5,0 хувиар бууруулж болохыг тогтоосон байна.

2003-2008 онд бүртгэгдсэн амиа егүүтгэсэн хэрэг учралын 0,9 хувь нь сэтгэцийн эмгэгийн улмаас үйлдэгдсэн байна. Сэтгэцийн эмгэгийн улмаас амиа егүүтгэсэн тохиолдлуудыг сэтгэц эмгэгийн оношоор үзвэл шизофрени өвчинтэй хүн амиа егүүтгэх нь давамгайлж байна¹⁰.

Цаашлаад цус ойртолт, стресс, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл нь амиа егүүтгэх сэдлийг өөгшүүлэгч тул хүн бүхний сэтгэлийг эмзэглүүлэх тулгамдсан асуудал мөн.¹¹

Улмаар бие хүн төлөвших процессын үед амьдралыг төсөөлөлд гутранги үзэл бий болж амьдралын тодорхой тохиолдолд сэтгэл зүйн хувьд шантрах нь амиа егүүтгэх нэг шалтгаан болж байна. Тухайлбал өсвөр насныхан ихэнхдээ бүтэлгүй хайр, санхүүгийн эх үүсвэргүй байдал, эцэг эхтэйгээ үл ойлголцох асуудал, архидалт гэр бүлийн хүчирхийлэл зэрэг гадны сэтгэл зүйн өдөөгч цочролоос ийм алхам хийдэг билээ.

“Монголын санхүүгийн зах зээлийн холбоо” 2014 оны 1 дүгээр улиралд Улаанбаатар хотын иргэдийн стрессийн түвшинг тодорхойлохоор судалгаа явуулж нийт иргэдийн ердөө 14 хувь нь стрессгүй амьдардаг¹² гэжээ.

Хэдийгээр сэтгэл зүйн зөвөлгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа ч төлбөртэй үйлчилгээг авах иргэд нийт хүмүүсийн тоон үзүүлэлтэнд бага хувь эзэлдэг байж болох талтай.


Өөрөөр хэлбэл эхнэр нөхөр, зарим тохиолдолд ажлын хэт ачаалал, амьдарлын зовлон бэрхшээлийг даван гарахын тулд үйлчлүүлж буй хэдэн хүнийг эс тооцвол, гэмт хэрэг, архидан согтуурал ба мансууралд өртөж болзошгүй эсвэл өртчихсөн, болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж ба өртүүлж болзошгүй иргэдийн дийлэнх нь энэ төв хаана байдаг, ер нь ийм төвүүд байдаг тухай мэдээлэлгүй байгаа нь их тохиолддог.

- Хэдийгээр шашин шүтэх эс шүтэх нь хүний эрхийн асуудал боловч шашны хууль бус байгууллагуудын үйл ажиллагаа, суртал ухуулга нь хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх элдэв ухуулгаас болж амиа егүүтгэх үзэгдэл гарч болзошгүй нь байдаг байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болжээ. Тухайлбал, зөвхөн сүүлийн 3 жил 8

¹⁰ ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС, СЭМТ. “2003-2008 онуудад Монгол улсад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлын тархалт” судалгааны ажлын тайлан, УБ, Дээрх судалгаагаар “амиа хорлох оролдлогыг дахин давтан үйлдэх тохиолдлыг судлахад 10,2 хувь нь анх удаа, 0,6 хувь нь хоёрдахь удаа, 0,1 хувь нь гуравдахь удаагаа энэхүү үйлдлийг хийжээ.”

¹² www.purplebook.mn/pdf/CSI%202014.Q1.pdf

Шийдвэрлэлт



сарын хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 1505 бүртгэгдсэн бөгөөд 49 хүн амь насаа алдаж, 1180 хүн гэмтсэн байна.¹³

Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй болон захиргааны зөрчилд тооцогдон арга хэмжээ авагдсан хүчирхийллийн тоо үүнээс даруй 5 дахин их байгааг энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудын судалгаа харуулж байна.¹⁴

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль хэрэгжиж эхэлснээс хойших 8 жил гаран хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах 41 шийдвэрийг шүүх гаргасан ч тэдгээр шийдвэрийн нэг нь ч хэрэгжээгүй байна.¹⁵

Амиа егүүтгэхэд хүргэх нь гэмт хэрэг болох нь

Хүн амьд явах эрхтэй бол үхэх эрхтэй юу гэдэг “зүй бус” ч гэсэн асуулт хөндөгдөж байна. Энэ нь дэлхийн анагаах ухаан эрдэнэт хүний амийг авч одох зарим аюулт өвчний өмнө хүчин мөхөсдөж одоог болтол эмчилгээгүй, эдгэршгүй гэх өвчнүүдийн жагсаалт улам бүр нэмэгдэхийн хэрээр зовж шаналсан хүний орь дуу тавин өвчин шаналалдаа энэлэхүй энэ ертөнцөөс халин одож ард үлдэх хүмүүсийн амьдрал ахуйд үл тээршаагдах гэсэн хүсэлтийг хэрхэх вэ.

Зарим тохиолдолд хүнд өвчтэй эдгэршгүй гэсэн оноштой хүмүүсийг ар гэрийнхэн нь хэдэн жил хамт байа гэхийн оронд тээршаасан байдлын улмаас өвчтөний сэтгэл зүй хүнд хямралд оруулдаг.

Эдгэршгүй өвчин туссаны улмаас насан туршдаа хүний гарын дор амьдрах болсон хүнд өвчтөнийг өөрийнх нь хүсэлтээр ар гэрийнхэн болон гадны ямар нэг нөлөө дарамт шахалтаар бус үхэхийг хүссэн иргэдийг эмч, хуулийн ажилтны хяналтанд өвчтөнийг зовж тарчлаалгүйгээр хүсэлтийг биелүүлэх байгаа олон улсын жишиг эрх зүйн зохицуулалт нэгэнт бий болжээ.

Харин Монгол Улсад амиа егүүтгэхэд хүргэх гэмт хэргийн шинжийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль түүнчлэн УИХ-д өргөн баригдсан шинэ Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд дараах байдлаар тусгажээ.

Хууль	Эрүүгийн хууль ¹⁶	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл ¹⁷
Зүйл	95 дугаар зүйл. Амиа хорлоход хүргэх	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх
Гэмт хэргийн шинж	Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол	Эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол
Ял	хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял

¹³ Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээ. 2010-2013 оны 8 сарын байдлаар.

¹⁴ ХЭҮТ-ийн судалгаа. 2010 он.

¹⁵ Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан. ННФ, ХЭҮТ. 2010 он.

¹⁶ Монгол улсын Эрүүгийн хууль Төрийн мэдээлэл 2002 оны № 5

¹⁷ Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. www.parliament.mn. хуулийн төслүүд

Түүнчлэн амиа хорлоход хүргэсэн байж болзошгүй тохиолдолд Эрүүгийн хуулийн 95-р зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэх нь нэг талаар онц хүнд гэмт хэргийн гаралтын талаар зохиомлоор тоог нэмэгдүүлэхгүй байх асуудалтай холбоотой юм.

Ер нь амиа егүүтгэсэн тохиолдол болгонд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа нь ЭБШ хуулийн 156-р зүйлд гадны нөлөөллөөр буюу сэжигтэй байдлаар нас барсан бол түүний шалтгааныг тогтоох, бие махбодид учирсан гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоохын тулд заавал шинжилгээ хийлгэх эрх зүйн зохицуулалттай холбоотой.

Дээрх дурьдсан гэр бүлийн хүчирхийлэл амиа егүүтгэх нэг хүчин зүйл болж байгаа төдийгүй амиа хорлоход хүргэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 95 буюу "Бусдыг амиа хорлоход хүргэх" зүйл ангиар нийт 169 хүнийг сэжигтнээр татаж, үүнээс 110 хүнд ял сонсгож яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт хүргүүлсэн байна.

Золгүй байдлаар болон амиа егүүтгэсэн тохиолдол бүрийн мөрдөн шалгах ажиллагааг цагдаагийн байгууллага мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахдаа хүнийг санаатай, болгоомжгүй байдлаар алах, амиа хорлоход хүргэх гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүйг анхаарч бодит үнэнийг тогтоон эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын хэрэгжилтийг хангахаар цагдаагийн байгууллага ажиллаж байна.

№	Он	Сэжигтнээр тооцсон хүн	Яллагдагчаар татсан хүн	Яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн
1	2012 он	48	27	27
2	2013 он	64	41	41
3	2014.10 сар	57	42	42
4	Нийт	169	110	110

Дүгнэлт

Гэр бүлийн таагүй орчин, хэрүүл маргаан, дарамт, айдас буюу гэр бүлийн хүчирхийлэл, эцэг, эхийн хараа хяналт, хайр халамж, хүүхдийн хүмүүжил, сэтгэл зүйн төлөвшил, амьдралд учрах элдэв хүндрэл, бэрхшээлийг даван туулах, тэсвэрлэх сэтгэл зүйн тэнхээгүй байдал, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ, согтууруулах ундаа хэрэглэсэн зэргээс шалтгаалан хувь хүний сэтгэл зүйн байдал, сэтгэцийн өвчин, түр сарнил, гутранги үзлээр нөхцөлдөн амиа егүүтгэх нийгмийн сөрөг үзэгдэл түгээмэл байна.

Өөрийн хүслээр амьд явах эрхээ хязгаарлан егүүтгэж буй хүмүүсийн шалтгаан, нөхцлийн

судалж мэдээллийн санг бүрдүүлэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон улсын жишиг, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, эрүүл мэнд, шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулахдаа Иргэний хяналтын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх олон нийтийн газруудыг байгуулах нь согтууруулах ундаагаар үйлчлэх газраас эдийн засгийн ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх тухайлбал, татварын хөнгөлөлтийн төрийн зохицуулалтыг хийх талаар холбогдох яам, агентлагт холбогдох саналыг хүргүүлэн хамтран ажиллах шаардлагатай байна.

Хотжилтын хүчин зүйлийн улмаас амиа егүүтгэх тохиолдлыг бууруулах зорилгоор нийслэл, аймгуудад иргэдийн стресс, сэтгэл гутралын тандалтыг явуулан, тэдгээрт сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх зорилгоор нийслэлийн дүүргүүд, аймагт сэтгэл зүйн төвүүдийг нээж ажиллуулах шаардлагатай байна.

Энэхүү сэтгэл зүйн төвүүдээр цагдаа, эрүүл мэндийн байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран амиа егүүтгэх нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээг авах боломж бүрдэнэ.

Улсын хэмжээнд гудамж талбай, орон сууц, амиа егүүтгэх оролдлого гарч байсан орчныг камержуулах хууль зүйн учир холбогдлыг таниулах ажлыг эрчимжүүлэн камержуулалт, дохиоллын системийг стандартыг зохих байгууллага тогтоож аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үр нөлөөтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэх нь чухал байна.

Жишээлбэл, амиа егүүтгэх нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэргийн цахим зураглалыг нэвтрүүлж, түүнтэй уялдуулан цагдаагийн хяналтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.